



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 415

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж,  
зээлийн хоршоо байгуулах хүсэлт хүлээн авах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн байгууллагын зохицуулалтын журам” болон “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам” шинэчлэн батлагдсан, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэл, зөвшөөрлийн програмыг суулгах, турших ажиллагаа 12 дугаар сарын 25-ны өдрөөс жигдэрч, шинэ журам, зарчмын дагуу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа явагдаж эхлэх болсонтой холбогдуулан Хорооны 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар /15 дугаар тэмдэглэл/ шийдвэрлэсэн ББСБ, ХЗХ шинээр байгуулах тусгай зөвшөөрлийн өргөдөл, хүсэлт хүлээн авах хугацааг сунгаж, 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөр тогтоосугай.

2. Энэхүү тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001100